



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/154/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудит газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Батжаргал Утас: 70584207 Цахим хаяг: Batjargalb@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НББ	Нягтлан бодох бүртэл



Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15



2.1. Оршил

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг **газрын дарга Д.Дамдинбазар** танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу **Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын** 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг **2020** оны 01 дүгээр сарын 25-аас 2020 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Б.Батжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 1/37 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын эрхэм зорилго нь “Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд геодези, зураг зүй, суурь судалгаа, газрын мониторинг, газар зохион байгуулалт, газрын кадастр, орон зайн мэдээллийн менежмент, барилга, хот байгуулалтын салбарын талаарх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн амьдрах болон баялаг бүтээх эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх”-д оршино.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Газрын харилцаа
- Барилга, хот байгуулалт

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acoluos программ хангамж ашигладаг байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд **дунд** гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар **Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын** бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд **12** эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 500,069.3 мянган төгрөгөөс тооцон 10,001.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 16,030.2 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27.99 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Мөнгөн хөрөнгө	-	-	-	
Авлага	319,165.00	55,376,149.00	55,056,984.00	17250.32
Урьдчилгаа	-	-	-	
Бараа материал	30,178,066.86	36,106,686.44	5,928,619.58	19.65
Үндсэн хөрөнгө	486,741,074.23	504,505,074.23	17,764,000.00	3.65
Хуримтлагдсан элэгдэл	(370,019,410.34)	(407,557,978.10)		0.00
Нийт хөрөнгө	147,218,895.75	188,429,931.57	41,211,035.82	27.99
Өр төлбөр	-	-	-	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	147,218,895.75	188,429,931.57	41,211,035.82	27.99
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	147,218,895.75	188,429,931.57	41,211,035.82	27.99

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 55,056.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн ОНХС-аас авч, улсын төсөвт төвлөрүүлэх 55,376,1 мянган төгрөгийн техник хяналтын зардлыг төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 5,928.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас бараа материал үнэ төлбөргүй олгосонтой холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 17,764.0 мянган төгрөгөөр өссөн нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас хөрөнгө үнэ төлбөргүй олгосонтой холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт 52,500.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байснаас жилийн эцсийн байдлаар 115,595.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. Орлого давуулан биелүүлсэн шалтгаан нь 2019 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудад эрх үүргийн хүрээнд хяналт тавин ажилласан.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 426,892.8 мянган төгрөг урсгал зардалд зарцуулагдахаар батлагдсанаас 418,802.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 23,786.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 152,686.8 мянган төгрөгийн нэмэлт орлого орсон байна. Үүнээс 119,600.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, бараа, ажил үйлчилгээний урсгал зардалд 33,186.8 төгрөгийг зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 12 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 112,122.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 55,376.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,370.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 1 зөвлөмж, 55,376.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд залруулга хийлгэлээ.

Аудитаар 56,746.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 55,376.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Аймгийн ОНХС-аас авч, төсөвт төвлөрүүлэх 55,376.1 мянган төгрөгийг техник хяналтын зардлыг төсөвт байгууллагын урьдчилгаа дансанд бичсэн нь *Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн “16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 1,370.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 7,417.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн бөгөөд биелэлтийг 2019 оны 5 дугаар сарын 10-ны 303 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид **Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын** 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар зүйл, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Гүйцэтгэлийн шатанд тодорхойлсон эрсдэл

1.1. Илрүүлэлт: Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлаас ажилтнуудад нийт 1,370.0 мянган төгрөгийн тэтгэмж олгохдоо өргөдөл холбогдох дэмжих баримтыг хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн “13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

1.3. Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>30,497,231.86</u>	<u>91,482,835.44</u>
33	АВЛАГА	319,165.00	55,376,149.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	55,376,149.00
35	БАРАА МАТЕРИАЛ	30,178,066.86	36,106,686.44
351	Түүхий эд материал	3,965,810.00	3,651,025.00
35110	Тусгай зориулалттай материал	3,965,810.00	3,651,025.00
354	Хангамжийн материал	26,212,256.86	32,455,661.44
35410	Бичиг хэргийн материал	2,978,746.00	3,333,725.00
35420	Аж ахуйн материал	18,409,049.80	22,243,862.22
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	2,546,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,824,461.06	4,332,074.22
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>116,721,663.89</u>	<u>96,947,096.13</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	116,721,663.89	96,947,096.13
392	Биет хөрөнгө	85,608,330.45	66,213,762.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	16,888,539.00	16,888,539.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-703,689.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,227,750.00	82,491,750.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-78,916,281.25	-82,491,750.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	313,688,528.28	335,288,528.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	-268,363,391.86	-298,835,165.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,121,523.95	32,021,523.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,038,337.67	-18,445,974.12
393	Биет бус хөрөнгө	31,113,333.44	30,733,333.52
39301	Программ хангамж	7,814,733.00	7,814,733.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6,701,399.56	-7,081,399.48
39303	Бусад биет бус хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>147,218,895.75</u>	<u>188,429,931.57</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>147,218,895.75</u>	<u>188,429,931.57</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	147,218,895.75	188,429,931.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	182,782,728.80	182,782,728.80
51101	Өмч: - төрийн	182,782,728.80	182,782,728.80
512	Хуримтлагдсан үр дүн	-55,702,244.09	-14,491,208.27
51210	Өмнөх үеийн үр дүн	-55,702,244.09	-55,702,244.09
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	41,211,035.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	20,138,411.04	20,138,411.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>147,218,895.75</u>	<u>188,429,931.57</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	459,153,480.70	842,723,579.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	42,711,051.00	236,097,894.00
120	Нийтлэг татварын бус орлого	42,711,051.00	236,097,894.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	42,711,051.00	236,097,894.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,711,051.00	214,963,994.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	21,133,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	62,068,629.70	187,823,385.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	354,373,800.00	418,802,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,349,462.70	152,686,885.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	54,349,462.70	152,686,885.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	23,786,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	23,786,800.00
1330	Төсвийн захирагчдаас	7,615,000.00	11,349,700.00
133003	Хөрөнгийн	7,615,000.00	11,349,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	500,069,386.17	801,512,543.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	500,069,386.17	801,512,543.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	412,793,191.47	504,664,822.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,579,578.00	322,574,965.00
210101	Үндсэн цалин	190,387,278.00	231,725,965.00
210102	Нэмэгдэл	33,717,300.00	65,963,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,369,400.00	8,141,000.00
210104	Урамшуулал	00.00	88,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	17,105,600.00	16,656,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,596,880.00	39,826,955.00
210201	Тэтгэврийн даатгал	19,942,649.00	27,335,673.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,365,189.00	2,359,565.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,979,212.00	3,233,116.00
210204	Ажилгүйдлийн даатгал	482,714.00	627,147.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,827,116.00	6,271,454.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,664,837.00	22,282,377.00
210301	Гэрэл, цахилгаан	1,383,840.00	1,383,840.00
210302	Түлш, халаалт	2,605,597.00	2,623,137.00
210303	Цэвэр, бохир ус	132,000.00	132,000.00
210304	Байрны түрээс	17,543,400.00	18,143,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,048,444.00	20,526,694.42
210401	Бичиг хэрэг	3,326,238.00	7,617,966.00
210402	Тээвэр, шатахуун	2,821,171.00	8,876,859.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	499,265.00	507,180.00



Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,681,820.00	1,388,270.00
210408	Бараа материал акталсны зардал	719,950.00	2,136,419.42
2105	Нормативт зардал	00.00	88,470.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	88,470.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	325,500.00	1,028,200.00
210604	Урсгал засвар	325,500.00	1,028,200.00
2107	Томилолт, зочны зардал	3,633,900.00	5,623,700.00
210702	Дотоод албан томилолт	3,633,900.00	5,623,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,256,030.00	12,526,047.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,998,600.00	8,515,382.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	37,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,191,630.00	3,973,065.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,688,022.47	80,187,413.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,745,487.00	35,912,846.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,942,535.47	44,274,567.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,276,194.70	296,847,721.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,230,000.00	15,696,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	14,326,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,230,000.00	1,370,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,705,441.00	45,956,377.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,705,441.00	1,261,322.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	44,695,055.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	915,000.00	119,600,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	915,000.00	119,600,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	80,425,753.70	115,595,044.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	80,425,753.70	115,595,044.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-40,915,905.47	41,211,035.82
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-40,915,905.47	41,211,035.82

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	451,434,313.70	754,863,830.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	42,711,051.00	159,587,845.00
120	Нийтлэг татварын бус орлого	42,711,051.00	159,587,845.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	42,711,051.00	159,587,845.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,711,051.00	159,587,845.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	408,723,262.70	595,275,985.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	354,373,800.00	418,802,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,349,462.70	152,686,885.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	54,349,462.70	152,686,885.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	23,786,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	23,786,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	445,497,413.70	749,193,830.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	445,497,413.70	749,193,830.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	358,221,219.00	452,346,109.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,794,576.00	322,268,198.00
210101	Үндсэн цалин	190,602,276.00	231,419,198.00
210102	Нэмэгдэл	33,717,300.00	65,963,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,369,400.00	8,141,000.00
210104	Урамшуулал	00.00	88,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	17,105,600.00	16,656,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,596,880.00	39,814,557.00
210201	Тэтгэврийн даатгал	20,050,789.00	27,205,012.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,321,903.00	2,372,660.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,896,307.00	3,358,741.00
210204	Ажилгүйдлийн даатгал	470,781.00	625,287.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,857,100.00	6,252,857.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,664,837.00	22,282,377.00
210301	Гэрэл, цахилгаан	1,383,840.00	1,383,840.00
210302	Түлш, халаалт	2,605,597.00	2,623,137.00
210303	Цэвэр, бохир ус	132,000.00	132,000.00
210304	Байрны түрээс	17,543,400.00	18,143,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,395,456.00	7,937,340.00
210401	Бичиг хэрэг	838,200.00	1,691,170.00
210402	Тээвэр, шатахуун	2,821,171.00	4,402,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	499,265.00	507,180.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,236,820.00	1,336,490.00
2105	Нормативт зардал	396,000.00	88,470.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	88,470.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	274,500.00	1,383,200.00
210604	Урсгал засвар	274,500.00	1,383,200.00
2107	Томилолт, зочны зардал	3,633,900.00	5,623,700.00
210702	Дотоод албан томилолт	3,633,900.00	5,623,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,064,400.00	8,552,982.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,998,600.00	8,515,382.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	37,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,400,670.00	44,395,285.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,400,670.00	44,395,285.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,276,194.70	296,847,721.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,230,000.00	15,696,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	14,326,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,230,000.00	1,370,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,705,441.00	45,956,377.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,705,441.00	1,261,322.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	44,695,055.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	915,000.00	119,600,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	915,000.00	119,600,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	80,425,753.70	115,595,044.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	80,425,753.70	115,595,044.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,936,900.00	5,670,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,936,900.00	5,670,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,936,900.00	5,670,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,936,900.00	5,670,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,936,900.00	5,670,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-5,936,900.00	-5,670,000.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	152,782,728.80	3,589,872.16	-14,786,338.62	141,586,262.34
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	152,782,728.80	3,589,872.16	-14,786,338.62	141,586,262.34
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00

C07	Тайлант үеийн үр дүн	30,000,000.00	00.00	-40,915,905.47	-10,915,905.47
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	182,782,728.80	20,138,411.04	-55,702,244.09	147,218,895.75
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	182,782,728.80	20,138,411.04	-55,702,244.09	147,218,895.75
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	182,782,728.80	20,138,411.04	-55,702,244.09	147,218,895.75
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	41,211,035.82	41,211,035.82
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	182,782,728.80	20,138,411.04	-14,491,208.27	188,429,931.57

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	442,589,100.00	441,327,778.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	442,589,100.00	441,327,778.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	426,892,800.00	425,631,478.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	316,713,800.00	316,060,198.00
210101	Үндсэн цалин	231,462,200.00	231,419,198.00
210102	Нэмэгдэл	65,963,400.00	65,963,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,751,600.00	8,141,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,536,600.00	10,536,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,589,200.00	39,184,197.00
210201	Тэтгэврийн даатгал	26,920,800.00	26,574,652.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,534,400.00	2,372,660.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,166,800.00	3,358,741.00
210204	Ажилгүйдлийн даатгал	632,400.00	625,287.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,334,800.00	6,252,857.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,400,700.00	22,282,377.00
210301	Гэрэл, цахилгаан	1,431,700.00	1,383,840.00
210302	Түлш, халаалт	2,643,700.00	2,623,137.00
210303	Цэвэр, бохир ус	181,900.00	132,000.00

210304	Байрны түрээс	18,143,400.00	18,143,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,614,000.00	7,607,340.00
210401	Бичиг хэрэг	1,445,500.00	1,441,170.00
210402	Тээвэр, шатахуун	4,322,500.00	4,322,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	499,900.00	507,180.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,346,100.00	1,336,490.00
2105	Нормативт зардал	96,000.00	88,470.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	96,000.00	88,470.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,386,100.00	1,383,200.00
210604	Урсгал засвар	1,386,100.00	1,383,200.00
2107	Томилолт, зочны зардал	5,545,400.00	5,544,200.00
210702	Дотоод албан томилолт	5,545,400.00	5,544,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	103,400.00	37,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	37,600.00	37,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33444200.00	33443896.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,444,200.00	33,443,896.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15696300.00	15696300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,696,300.00	15,696,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,326,300.00	14,326,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,370,000.00	1,370,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	442,589,100.00	441,327,778.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	418,802,300.00	417,662,201.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	418,802,300.00	417,662,201.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,786,800.00	23,665,577.00
132001	Орон нутгийн төсвөөс	23,786,800.00	23,665,577.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30.00	30.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	27.00	27.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00